

Р.Саранцэцэг: Инфляцид улс төр нөлөөлдөг

Инфляци өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй гарч байна. Монголбанкны үзэж байгаагаар цаашид инфляцийг барих талаар олон талын арга хэмжээ авах шаардлагатай аж. Энэ талаар Мөнгөний бодлогын хэлтсийн захирал Р.Саранцэцэгтэй ярилцав.

- Ямар учраас олон улсын санхүүгийн байгууллагууд төсвийн тэлэлтэд шүүмжлэлтэй хандаж байна?
- Олон улсын санхүүгийн байгууллагууд манай эдийн засгийг дүгнэхдээ “хэтэрхий халсан, тэлсэн” гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлт тодорхой түвшинтэй байдаг. Гэтэл манай эдийн засаг энэ түвшингээс хурдацтай өсч байна. Энэ нь эргээд тодорхой хугацааны дараа огцом уруудах аюул дагуулдаг. Дэлхийн эдийн засаг хямраад эхлэхэд л дагаад унахад бэлэн болчихоод байна. Энэ дүгнэлттэй Монголбанк ч санал нэг байна.
- Монголбанк бодлогын хүүгээ нэмсэн нь зээлийг хумчихлаа гэсэн шүүмжлэлд өртөж байна.
- Эдийн засагт бараа, үйлчилгээ нийлүүлэх чадамж гэж байдаг. Нөгөө талд түүнийг худалдаж авах мөнгө байх ёстой. Гэтэл бараа, үйлчилгээнээсээ илүү их хэмжээний мөнгө иргэдийн гар дээр очиж байна. Энэ тохиолдолд иргэдийн гар дээр илүүдэл мөнгө бий болно. Бараа нь цөөхөн, мөнгөний тоо хэмжээ нь их болохоор хэн илүү мөнгө өгсөн нь бараагаа худалдан авна. Ийм байдлаар барааны үнэ өснө. Тэгэхээр илүүдэл мөнгийг хязгаарлах шаардлага гарна. Энэ зорилгоор л бодлогын хүүг нэмж байгаа. Монголбанкны бодлогын хүү нэмэгдэхээр зээлийн хүү өсч болно. Гэхдээ сүүлийн үед гаднаас орж ирэх валютын урсгал их байна. Хэдийгээр бид мөнгөний нийлүүлэлтэд хориг тавьж байгаа боловч гаднаас орж ирж байгаа мөнгөний хэмжээ зээлийн хүүг огцом өсгөхгүй байгаа.
- Инфляцийн бүтэц ямар байгаа бол?
- Саяхан Монголбанк инфляцийг бууруулж зарладаг тухай ташаа мэдээ гарсан. Инфляцийн мэдээг Үндэсний статистикийн хороо зарладаг. Монголбанк тэр мэдээг хэрэглэгч. Инфляци юунаас болоод байгааг судлах зорилгоор Монголбанк статистикийн мэдээг задалдаг. Эндээс бид аливаа барааны хомсдлоос болсон түр зуурын үнийн өсөлт байна уу, мөнгөний нийлүүлэлтээс үүссэн тодорхой хугацааны үнийн өсөлт байна уу гэдгийг тодорхойлно. Эндээс бид суурь инфляцийг зарлана.
- Одоогийн инфляцийн өсөлт юунаас үүсч байна?
- Мөнгөний нийлүүлэлтээс.
- Бараа, түүхий эдээс хамгийн их өссөн нь?
- Махны үнэ жаахан өссөн. Гэхдээ инфляцийн гурван хувийг л эзэлж байна.
- Түлшний онцгой албан татварыг тэглэсэн. Оросууд үнэ нэмбэл манайд бас нэмэгдэнэ. Нефтийн үнийн өсөлт инфляцийн хэдэн хувийг эзэлж байна?
- Нефть хэрэглээний сагсанд махыг бодвол бага хувь эзэлдэг. Гэхдээ махны үнэ нэмэгдэхэд зөвхөн махан бүтээгдэхүүний үнэ л нэмэгдэнэ. Харин нефтийн үнэ өсөхөд бусад бараа, үйлчилгээний үнэд үзүүлэх нөлөө нь их өндөр байдаг.
- Өнгөрсөн оны мөнгөний бодлого хэрэгжсэнгүй. Энэ жил яах бол?
- Та хэрэгжсэнгүй гэж буруу яриад байна. Гадныхан өнгөрсөн жил манайд инфляци 20-30 хувь хүрнэ гэж ярьж байсан. Гэтэл тийм юм болоогүй. Энэ нь мөнгөний тодорхой бодлого хэрэгжүүлсэний үр дүн. Хэрэгжсэн учраас мөнгөний нийлүүлэлт багасч, хямралын дараах үетэй харьцуулахад банкуудын чадавх тодорхой хэмжээгээр дээшилж байна. Бидний

явуулсан мөнгөний бодлогын үр дүн нь тэр яриад байсан 20-30 хувийн инфляцийг хязгаарласан.

- Энэ жил нэг оронтой тоонд барих уу?
- Бид бол барихын төлөө бүхий л хүчээ дайчлана. Гэхдээ инфляцийг барих нь дан ганц Монголбанкнаас хамаарахгүй. Улс төрийн алхам нөлөөлнө шүү дээ. Х.Баттөгс